



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 1/31

Улаанбаатар хот

**Эрүүл ажлын байр удирдамжийг
хэрэгжүүлэх тухай**


Эрүүл мэндийн сайдын 2013 оны 5 сарын 21-ний өдрийн “Эрүүл мэндийг дэмжигч байгууллагыг шалгаруулах болзол журмыг шинэчлэн батлах тухай” 197 дугаар тушаал, Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогчийн 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн удирдамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл ажлын байр” удирдамж, үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр, хэрэгжүүлэх ажлын хэсгийг хоёрдугаар, дүгнэх аргачлалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндэд ээлтэй ажлын байр бий болгож, ажилчдын эрүүл мэндийг хамгаалж, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд нийт эмч ажилчдыг хамруулж идэвхитэй оролцуулахыг ажлын хэсэг болон тасаг нэгжийн дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг эмчилгээ чанарын хяналтын албаны дарга /Э.Цэвэлмаа/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БОДЬЦЭЦЭГ

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 06 сарын 08-ны өдрийн
431 дугаар тушаалын хавсралт

"Эрүүл ажлын байр" зохион байгуулах удирдамж 9120262

Нэг. Нийтлэг үндэслэл

1997 оны Люксембургийн тунхаглалд "Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих" гэдэг нь ажил дээр нь хүмүүсийн эрүүл мэндийг сайжруулахын төлөөх ажил олгогч, ажилчид ба нийгмийн хамтарсан чармайлт гэж тодорхойлсон байна

Ажлын байр нь ажилчдын "бие махбодын, оюуны, эдийн засгийн хийгээд нийгмийн сайн сайхан байдалд" нөлөөлдгийн зэрэгцээ" тодорхой хүрээний хамт олон хүмүүсийн эрүүл мэндийг дэмжих нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Хоёр. Зорилго.

Хүн бүр эрүүл мэндийг дэмжсэн, аюулгүй, амгалан тайван орчинд бусдад үнэлэгдэн хүндлэгдэж ажиллахыг хүссэн, нөгөө талаас ажил олгогчид бүтээмж өндөртэй, ажилдаа махруу, бие сэтгэлээ зориулдаг ажилтнуудыг хүсэмжилдэг.

Ажилтан, ажил олгогч хоёрын хүсэх энэхүү хүсэл зөвхөн эрүүл мэндийг дэмждэг эрүүл ажлын байранд л биелэлээ олоход оршино.

Гурав.Зорилт

"Нийтийн эрүүл мэнд"-ийг бий болгоход эрүүл, аюулгүй орчин, эрүүл мэндийн зохих боловсрол бас хариуцлагатай иргэд, эмнэлгийн чанартай тусламж, үйлчилгээ цогцоороо нийлж байж олноороо эрүүл саруул байх болно.

Зорилт – 1. Шийдвэр гаргагч болон ажилчдын эрүүл ажлын байрны талаарх мэдлэг хандлагыг дээшлүүлж, ажлын байрны зохион байгуулалт, ажиллах орчныг сайжруулах			
№	Хэрэгжүүлэх ажил	Шалгуур үзүүлэлт	Хариуцах эзэн
1	"Эрүүл ажлын байр" удирдамжийг хэрэгжүүлэх ажлын бүрэлдэхүүн томилж төлөвлөгөө гаргах	Удирдлагаар хангасан тодорхой ажил гүйцэтгэх	НЭМТҮХ орлогч дарга
2	Бүх ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүл мэндийн түвшин тогтоож, үзүүлэлтийг дээшлүүлэх арга хэмжээ авах	Үзлэгээр илэрсэн өвчлөлд дүгнэлт хийж эрсдэлийг бууруулах, эрүүлжихэд нь дэмжлэг үзүүлэх	Хүний нөөцийн менежер Эмч ажилчдын эмч
3	Бүх ажилчдыг бие бялдрын чийрэгжилтийн түвшин	Бие бялдрын чийрэгжилтийн	Биеийн тамир чийрэгжилтийн арга зүйч

	тогтоож сайжруулах арга хэмжээг зохион байгуулах	үзүүлэлт, авсан арга хэмжээ, үр дүн	
4	Ажлын байранд хийх дасгал хөдөлгөөнд хамт олны хамруулж хэвшүүлэх	Бодит байдал, нэрсийн жагсаалт, хөтөлбөр хуваарь	Тасаг нэгжийн дарга, Биеийн тамир чийрэгжилтийн арга зүйч
5	Эрүүл, аюулгүй орчинд ажиллах, алжаал тайлах, амрах нөхцөл бололцоогоор хангагдсан байх	Ажилчид үдийн хоолонд шаардлага хангасан цайны газар болон гуанзанд орох	Халдвар судлаач нар, аж ахуйн дарга, санхүү
6	Эмч ажилчдын дотроос “Эрүүл иргэн”, “Эрүүл өрх”-ийг шалгаруулж бусдад сурталчилах	Тодорхой үзүүлэлтийн дагуу	Ажлын хэсэг НЭМТҮХ орлогч дарга
7	Хамт олны нөхөрсөг, харилцан бие биеэ хүндэтгэсэн, эелдэг зөөлөн харилцааг эрхэмлэдэг, бие биеэдээ тусалж дэмждэг болсон байх	Санал хүсэлт, гомдол, шүүмжлэлийн мөрөөр авсан арга хэмжээ, асуумж судалгаа	Ажлын хэсэг, Чанарын алба, хүний нөөц
8	Байгууллагын гадаад орчныг тохижуулсан, аюулгүй байдлыг хангах	Гадаад орчны зураг, хийшдсэн ажлууд	Аж ахуйн , Ажлын хэсэг
Зорилт – 2. Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн нөхцөлийг ажлын байранд бий болгох, хүн бүрийн идэвхтэй оролцоог дэмжих			
1	Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх нөхцөлийг бүрдүүлэх	Эмч ажлчдын эрүүл мэндийн өвчлөлийн судалгааны дүгнэлт	Ажилчдын эмч, БТЧ-ийн арга зүйч
2	Хорт зуршлын судалгааг гаргаж, тодорхой арга хэмжээг авах	Сургалт зохион байгуулах, судалгааг үндэслэж хийгдсэн ажлууд	Наркологийн эмч, ЭМ-ийн МСС арга зүйч
3	Ажлын байрны дотоод орчны агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн авсан арга хэмжээ	Судалгаа гаргах, Амьсгарын замын өвчлөлийн судалгаа	Тархвар судлаач, Ажилчдын эмч
4	Ажиллагсадад “Халдварт бус өвчин”-ий эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн мэдлэгийн түвшин тогтоох	Судалгаа дүгнэлт хийж тодорхой арга хэмжээ авсан байх	Ажлын хэсэг

5	Хамт олны дунд спорт, соёл урлагийн болон бусад арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Ажлын төлөвлөгөө, зураг шагнал урамшуулал, хамт олны дунд явуулсан асуумжийн үр дүн	Ажлын хэсэг
6	Олон нийтийг хамарсан соёл спорт, урлаг, нийтийн биеийн тамрийн болон бусад арга хэмжээнд идэвхитэй оролцож амжилт гаргах	Тушааль тайлан зураг бусад бичиг баримт, шагнал урамшуулал	Ажлын хэсэг
Зорилт – 3. Эрүүл ажлын байрыг нийтэд сурталчилах тэргүүн туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилах, хувь хүний хөгжлийг дэмжих.			
1	Эмч ажилчдад болон үйлчлэх хүрээний иргэдэд эрүүл ажлын байрны талаар сургалт сурталчилгаа хийх	Халдварт бус өвчнөөс өөрсдийгөө хамгаалах ойлголттой болох	Эрүүл мэндийн мэдээлэлийн сургалт сурталчилгаа хариуцсан арга зүйч
2	Ажлын байран дах осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн талаар эмч ажилчдад хичээл сургалт оруулах	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүл ахуйн тогтолцооны суурь судалгааг үндэслэн сайжруулсан байх	Аж ахуйн дарга, Хүний нөөц, тасаг нэгжийн дарга нар
3	Архи тамхигүй хамт олон болох хөдөлгөөн өрнүүлэх	Хөтөлбөр, архи тамхи хэрэглэдэг хүний судалгааг үндэслэх	ЭМ-ийн МСС-нй арга зүйч Наркологийн эмч
4	Эрүүл мэндийн танхимд үйл ажиллагааг тогтмолжуулах	Гүйцэтгэсэн ажил болон, танхим тоног төхөөрөмж, хөтөлбөр	Ажлын хэсэг
5	Хамт олон Эрүүл ажлын байрны талаар сургалтанд хамрагдаж хүн бүр эрүүл мэндээ хамгаалж, бэхжүүлэх мэдлэг дадалтай, бусдад туслах чадвартай болсон байх	Хөтөлбөр, хамт олноос авсан судалгаа асуумж, нэрс, хуваарь, тайлан	Ажлын хэсэг
6	Нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх үзлэгийг хийж эрүүлжүүлэх арга хэмжээ авах	Эрүүл мэндийн үзлэгийн төрөл, давтамж, хийсэн ажиллагаа, судалгаа, үр дүн	Поликлиникийн тасаг Ажлын хэсэг

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 06 сарын 08-ны өдрийн
А/31 дугаар тушаалын хавсралт 2

**“ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР” ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Б.Лувсанням - Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга
Нарийн бичгийн дарга: Б.Билэгбат- Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт
сурталчилгааны арга зүйч

Гишүүд: -Э.Цэвэлмаа - Чанарын албаны дарга -
Ц.Энхбаясгалан - Хүний нөөцийн менежер -
Д.Энхбаяр - Ахлах нягтлан бодогч
Т.Соёл-Эрдэнэ - Поликлиникийн эрхлэгч
Ж.Оюунцэцэг - Эм зүйч
Д.Ичинхорлоо - Орчны эрүүл ахуйч тархвар судлаач
Ө.Ариунжаргал - Халдвар судлаач
О.Ууганбаяр - Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн
Г.Үүрийнтуяа - Өрхийн менежер
Ж.Соёлмаа - Нийтийн биеийн тамир чийрэгжилтийн арга зүйч -
Н.Сансар - Эх барих эмэгтэйчүүдийн ахлах мэргэжилтэн -
Б.Онон - Хүүхдийн ерөнхий зохицуулагч
Б.Нарангэрэл - Сүрьегийн ахлах зохицуулагч
Р.Болормаа - ХДХВ/ДОХ-ын эмч
П.Төгсжаргал - Халдвартын эмч
Б.Долгормаа - Ахмадын эмч
Б.Оюунчимэг - Сэтгэцийн эмч
Д.Пүрэвсүрэн - Наркологийн эмч
Л.Мэдэхгүй - Хоол боловсруулах эрхтний эмч
Ц.Отгонжаргал - Дотоод шүүрэл булчирхайн эмч
П.Отгонтунгалаг - Зүрх судасны эмч

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 06 сарын 08-ны өдрийн
А/31 дугаар тушаалын хавсралт 3

“ЭРҮҮЛ АЖЛЫН БАЙР”-ЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ
ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

№	Шалгуур	Биелэсэн эсэх
1	Удирдлагын дэмжлэг	
2	Ажиллагсдын оролцоо	
3	Төлөвлөгөө, хэрэгжилт	
4	Санхүүжилт	
5	Ажилчид эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх	
6	Ажилчид бие бялдарын түвшин тогтоох сорилд орсон байх	
7	Эрүүл ажлын байр сургалтуудыг хийсэн байх	
8	Чийрэгжүүлэх ба дасгалын өрөө тасалгаа, заалтай байх	
9	Жингийн илүүдэл буурсан байх	
10	Хорт зуршлын хэрэглээ буурсан байх	
11	Эрүүл, зөв хооллолттой болсон байх	
12	Даралтны аппарат, эмийн сантай байх	
13	Гар ариутгах нөхцөлөөр хангагдсан байх	
14	Агаарын бохирдлыг бууруулах агаар шүүгчтэй байх	
15	Байгууллагынхаа хэмжээнд эрүүл иргэн, эрүүл мэндээ дээдлэгч өрхийг шалгаруулсан байх	
Үр дүнгийн шалгуур		
16	Хорт зуршлын хэрэглээ буурсан байх	
17	Жингийн илүүдэл буурсан байх	
18	Ажлын байран дахь стресс, бухимдлыг бууруулсан байх	
19	Өвчнөөс шалтгаалсан чөлөө авалт байгассан байх	

1.Шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 0-5 оноогоор дүгнэнэ

- 1.1. Тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн бол 5 оноо
- 1.2. Тавьсан зорилтдоо 70.0-89.9 бол 4 оноо
- 1.3. Тавьсан зорилтдоо 50.0-69.9 бол 3 оноо
- 1.4. Тавьсан зорилтдоо 30.0-49.9 бол 2 оноо
- 1.5. Тавьсан зорилтдоо 29.9 хүртэл бол 1 оноо
- 1.6. Ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 оноо

Жич: Эрүүл ажлын байр, тэргүүн туршлагыг нийтэд сурталчилсан бол 2 оноо, хийгээгүй бол 0 оноо байна.